

ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН 2018 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018 оны 10 дугаар
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас энэ оны гуравдугаар улиралд Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийн хүрээнд 2018 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль зүй, дотоод хэргийн яамны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, зорилт болон холбогдох эрх зүйн баримт бичиг, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд урд онуудад хийгдсэн хэрэглэгчийн үнэлгээ, эрсдэлийн үнэлгээний тайлан, дэвшүүлсэн зорилт, түүний хэрэгжилт, алба нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас ирүүлсэн санал зэргийг судалж, “Удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын ажлын хариуцлага, ёс зүйг дээшлүүлж, ил тод, шударга, шуурхай, хуульч ажиллагааг хэвшүүлнэ” гэсэн зорилтыг дэвшүүлэн, үйл ажиллагааны төлөвлөгөө, зорилтын шалгуур үзүүлэлтийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/01 дүгээр тушаалаар баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргатай алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нараас 2017 онд байгуулсан менежерийн үр дүнгийн гэрээг Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоол, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Алба хаагчийн ажлыг үнэлэх /код 111/ журам”-ыг баримтлан дүгнэж, Цагдаагийн байгууллагаас 2017 онд дэвшүүлсэн зорилт, менежерийн үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад идэвх санаачилга, үр бүтээл гарган ажиллаж, аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн удирдах ажилтнуудыг манлайлан, “Хангалттай” үнэлэгдсэн цагдаагийн дэд хурандаа Б.Ганзориг даргатай Төв аймаг дахь цагдаагийн газрын хамт олныг Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны А/57 дугаар тушаалаар шагнаж, урамшуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, төсвийн төвлөрүүлэн захирагчаас менежер /21 аймаг дахь, цагдаагийн газар, хэлтсийн дарга, Тэргүүн дэд, Дэд, Дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн газрын дарга, Захиргааны удирдлагын газар, Дотоодын цэргийн штаб, Санхүү, аж ахуйн алба, Эрүүгийн цагдаагийн алба, Мөрдөн байцаах алба, Хэрэг бүртгэх алба, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, Замын цагдаагийн алба, Тусгай ажиллагааны газар, Хэвлэл, мэдээллийн төв, Төмөр зам дахь цагдаагийн газар, Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтэс, Хар тамхитай тэмцэх газар, Интерполын үндэсний төв товчооны ажлын албаны дарга/-тэй 2018 оны үр дүнгийн гэрээг байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдах ажилтны 2018 оны сургалт, зөвлөгөөнийг энэ оны 01 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, 137 алба хаагчийг хамруулсан.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагч, ажилтны эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны А/135 дугаар тушаалаар “Эрүүл цагдаа” хөтөлбөр, алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга, байгууллагын соёлын түвшинг дээшлүүлэх зорилгоор мөн оны А/120 дугаар тушаалаар “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёлыг төлөвшүүлэх хөтөлбөр”, “Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г тус тус баталж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн “Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр /2019-2022 он/-ийн төслийг Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-д нийцүүлэн шинэчлэн боловсруулах” чиглэлийн дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/235 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор зарим нэгжид бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт оруулах санал бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, бүтцэд хамрагдах нэгжүүдийн алба хаагчдаас санал авч нэгтгэн, Хууль зүй, дотоод хэргийн сайдад уламжилснаар салбарын сайдын энэ оны А/159 дүгээр тушаалаар Замын цагдаагийн алба, Төмөр зам дахь цагдаагийн газар, Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтсийг нэгтгэн “Тээврийн цагдаагийн алба”, Мэдээлэл нэгтгэн боловсруулах газар, Мэдээллийн технологи, холбооны төв, Мэдээлэл, шуурхай удирдлагын төв, Шуурхай удирдлага, ажиллагааны хэлтсийг нэгтгэн “Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба”-ыг тус тус байгуулсан.

Үүнтэй холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/214 дүгээр тушаалаар Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны даргыг Цагдаагийн ерөнхий газрын даргын дэргэдэх зөвлөх эрх бүхий зөвлөлийн гишүүнд оруулж, Тээврийн цагдаагийн болон Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны даргын дэргэдэх зөвлөх эрх бүхий зөвлөлийн гишүүдийг шинээр байгууллаа.

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар төв байрны бүтцэд Хар тамхитай тэмцэх газрыг харьяалуулж, Хүний нөөц, сургалтын хэлтсийг Хүний нөөцийн хэлтэс, Соён гэгээрүүлэх, албаны сургалтын тасгийг Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэс, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанд Зөрчил шалган шийдвэрлэх хэлтэс, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад Шуурхай удирдлагын тасаг, Баян-Өлгий, Төв, Увс, Хэнтий аймаг дахь цагдаагийн газарт Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсгийг тус тус байгуулж, Сүүж-Уул сэргээн засах амралт, сувиллын нэршлийг “Сүүж-Уул” амралт, сэргээн засах сувилал болгон өөрчилж, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, Тээврийн цагдаагийн алба, Авто бааз, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй хангах алба, Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газрын бүтэц, орон тоог шинэчлэн, Орхон аймаг дахь дотоодын цэргийн гэрээт тусгай салбарт орон тоо нэмж, харьяалал тодотгон, “Сүлд” чуулга, Төв архив болон Баянхонгор, Орхон, Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газрын орон тоонд өөрчлөлт оруулж, шийдвэрлэсэн.

Цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтаар зарим алба, нэгжийн ажлын байр, албан тушаалын нэршил, чиг үүрэг өөрчлөгдсөнтэй холбоотой ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод дүгнэлт хийх, ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж байна.

Дээрх ажлын хүрээнд Мөрдөн байцаах албаны 49, Хэрэг бүртгэх албаны 8, Дотоодын цэргийн штабын 64, Тусгай ажиллагааны газрын 22, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн 43, Хүч спорт хорооны 4, Гэрч хохирогчийг хамгаалах хэлтсийн 11, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн 22, Урьдчилан сэргийлэх хэлтсийн Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасгийн 2, Нийслэлийн цагдаагийн газрын Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн 2, Гадаад харилцааны хэлтсийн 1, Интерполын үндэсний төв товчооны 2, Аюулгүй байдлын хэлтсийн 5, Мэдээллийн технологи, холбооны төвийн 2, Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Хэрэг бүртгэх тасгийн 3, Мөрдөн байцаах тасаг, хэсгийн 3, Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэжилтний 1, Хэвлэл, мэдээллийн төвийн 8, Төв архивын 8, Хар тамхитай тэмцэх газрын 10, Эрүүгийн цагдаагийн албаны 32, нийт 19 алба, нэгжийн 302 ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтыг боловсруулан баталгаажуулсан.

Тайлангийн хугацаанд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 3 удаагийн шуурхай хуралдаанаас цагдаагийн байгууллагад цаг үеийн шинжтэй өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч, биелэлтийг тогтоосон хугацаанд тайлагнасан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанаар 2018 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг батлан, 11 удаагийн хуралдааныг зохион байгуулж, гарсан шийдвэр, мэдээлэл, үүрэг, чиглэлийг холбогдох алба, нэгжид хүргүүлэн, үр дүнг тогтоосон хугацаанд тооцон ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын удирдлагаас алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын 5600 гаруй алба хаагчид, 21 аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, хууль сахиулах болон тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын 97 удирдах албан тушаалтантай уулзалт зохион байгуулж, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газраас хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрийг танилцуулж, ажлын чиглэл, зөвлөмж хүргүүлж, тэдний санал, хүсэлтийг хүлээн авч, хэрэгжүүлэх чиглэлээр үе шаттай арга хэмжээ зохион байгуулан ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, удирдлагаас XVII жарны “Тийн унжлагат” хэмээх “Шороон нохой” жилийн сар шинийн баяр, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 97 жил, казах түмний Наурызын баяр, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Тулгар төрийн 2227, Их Монгол Улсын 812, Ардын хувьсгалын 97, Цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсаны түүхт 97, Дотоодын цэргийн 96, Эрүүгийн цагдаагийн албаны 84 жилийн ойн баяр зэрэг тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын ажилтан, алба хаагчид, ахмад настан, тэдний гэр бүл, хүүхэд багачуудад мэндчилгээ дэвшүүлэн, баяр хүргэсэн.

Цагдаагийн ерөнхий газрын удирдлагууд Баянзүрх дүүргийн 8 дугаар хороонд баригдсан цагдаагийн алба хаагчдын 180 айлын орон сууцны барилгын, Монгол Улсын гавьяат хуульч, Хууль зүйн ухааны доктор профессор, хошууч генерал Б.Пүрэвийн амьдралаас сэдэвлэн бүтээгдсэн “Цагаан шонхор” баримтат киноны, цагдаагийн байгууллагын ахмад настуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх ёслолын, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2018 оны аварга шалгаруулах цогцолбор тэмцээний, Хууль Сахиулахын Их сургуулийн төгсөгчдөд диплом, энгэрийн тэмдэг гардуулах ёслолын арга хэмжээнд тус тус оролцож, алба хаагч, төгсөгчид, ахмад ажилтнуудад баяр хүргэсэн.

Архангай, Булган, Хэнтий аймаг дахь цагдаагийн газрын 80, Төв аймаг дахь цагдаагийн газрын 75, Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газрын Мандал сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн 60, Багануур дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн 40, Цагдаагийн ерөнхий газрын Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Багахангай дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн 25 жилийн ойн арга хэмжээг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Ой тэмдэглэн өнгөрүүлэх /код 125/” журамд заасны дагуу байгууллагын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх зөвшөөрлийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/64 дүгээр тушаалаар олгож, үүрэг, ажлын чиглэлийг хүргүүлсэн ба Архангай, Булган, Хэнтий, Төв аймаг дахь цагдаагийн газар, Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газрын Мандал сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс ойн арга хэмжээгээ ёслол, төгөлдөр тэмдэглэн өнгөрүүллээ.

Монголын уламжлалт “Цагаан сар”, сар шинийн баяр, Тулгар төрийн 2227, Их Монгол Улсын 812, Ардын хувьсгалын 97 жилийн ой, Үндэсний их баяр наадам, баяр амралтын өдрүүдэд иргэд, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдыг өндөржүүлсэн бэлэн байдлын хоёрдугаар зэрэгт шилжүүлж, өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажиллах үүрэг, чиглэлийг хүрүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж, баяр наадам, баяр амралтын үеийн хэв журмын болон эрүүгийн нөхцөл, байдлын талаар Монгол Улсын ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Монгол Улсын ерөнхий сайд, Монгол Улсын шадар сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тус тус тайлагнасан.

Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын даргын 2018 оны 34 дүгээр тушаалаар Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэвлэмэл болон видео /цахим/ танилцуулгын эх бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, хэвлэмэл танилцуулгыг “Мөнхийн үсэг” ХХК-иар, нэг бүрийг 2020 /хоёр мянга хорь/, видео /цахим/ танилцуулгыг “СН.Ж.СН” студийр 5.000.000 /таван сая/ төгрөгийн өртөгтэйгөөр гүйцэтгүүлж, тус бүр 1000 ширхэгийг хувилуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Цагдаагийн байгууллагын ахмадын холбоо, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын ахмадын хороо, зөвлөлийн үйл ажиллагааг дэмжин, “Ахмадын сан”-г хууль, тогтоомжийн хүрээнд идэвхжүүлж, шаардагдах хөрөнгийг тооцон, жил бүрийн төсөвт тусгуулах, бүрдүүлэх, санхүүжүүлэх, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн энэ оны “Ахмад настуудын талаар авах зарим арга хэмжээний тухай” А/223 тушаалыг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хүний нөөцийн чиглэлээр: Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдааны шийдвэрээр бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан 2339, шилжүүлэн буюу зохицуулсан 691, офицерын бүрэлдэхүүнд 234, офицер, дадлагажих ажилтнаар 29, хүүхэд асрах чөлөө, групп цуцалсан 30, шинээр албаны даргаар 2, газар, хэлтсийн даргаар 37, тасаг, хэсгийн даргаар 144, чиглэлийн ахлахаар 16, ахлахаар 171, нөөцөд авсан алба хаагчаас 5, Хууль сахиулахын их сургууль, Оросын холбооны улс, Туркийн сургуулийн төгсөгчөөс 169, сургуулийн чөлөө дуусч, эргүүлэн томилсон 11, төрийн бусад байгууллагаас шилжүүлэн 14 алба хаагчийг тус тус томилсон.

Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалтаар 25, өөрийн хүсэлтээр 83, цэгийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон 203, хүүхэд асрах чөлөө авсан 43, чөлөөлсөн 8, данс бүртгэлээс хассан, сэлгэн ажиллуулсан, сургалтын чөлөө авсан тус бүр 4 алба хаагчийг албанаас чөлөөлж, цагдаагийн байгууллагын ёс зүйг ноцтой зөрчсөн 12, гэмт хэрэг үйлдсэн 6, ажлын байр /албан тушаал/-ны шаардлага хангахгүй 1, сахилгын шийтгэлээр цагдаагийн байгууллагад 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр 31 алба хаагчийг албанаас халсан.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дэд дарга, Захиргааны удирдлагын газрын даргын тушаалаар 1870 алба хаагч цагдаагийн цол /хугацааны цагдаагийн хурандаа 17, дэд хурандаа 52, хошууч 402, ахмад 442, ахлах дэслэгч 252, дэслэгч 271, ахлах ахлагч 8, ахлагч 1, дэд ахлагч 242, зэрэг дэв дээгүүр цагдаагийн хурандаа 7, дэд хурандаа 8, хошууч 7, хугацааны өмнө цагдаагийн хурандаа 7, цагдаагийн дэд хурандаа 11, цагдаагийн ахмад 2, цагдаагийн ахлах дэслэгч 4/ шагнагдаж, 37 алба хаагчийн цагдаагийн цол /цагдаагийн хурандаа 1, дэд хурандаа 4, хошууч 4, ахмад 14, ахлах дэслэгч 13, дэслэгч 1/-ийг сэргээж, Дотоодын цэргийн командлагчийн тушаалаар 40 алба хаагчид дотоодын цэргийн цол /дотоодын цэргийн дэд хурандаа 6, хошууч 9, ахмад 3, дэслэгч 22/ олгосон.

Цагдаагийн албаны тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 74 дүгээр тогтоолын дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар аймгийн төвөөс бусад суманд 5-аас дээш жил ажилласан 103 алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшил, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон 207 алба хаагчид 36 сарын цалин, хөлстэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж, цэргийн алба хаасны тэтгэвэр хувь тэнцүүлэн тогтоолгосон 3 алба хаагчид 18 сарын цалин, хөлстэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн 3 алба хаагчид 18 сарын цалин, хөлстэй тэнцэх хэмжээний урьдчилгаа тэтгэмж, нас барсан 6 алба хаагчийн ар гэрт 36, 2 алба хаагчийн ар гэрт 60 сарын цалин, хөлстэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж тус тус олгохоор шийдвэрлэж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан 49 алба хаагчийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн одон медалиар, 150 алба хаагчийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар салбарын яамны шагналаар, 1939 алба хаагчийг Цагдаагийн ерөнхий газрын шагналаар шагнаж, урамшуулсан ба албандаа хайнга хандсан, сахилга, ёс зүйн зөрчил, дутагдал гаргасан 126 алба хаагчид сахилгын арга хэмжээ авсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан “Алба хаагчид албаны үнэмлэх, энгэрийн тэмдэг олгох, хураан авах журам /код 916/-д

заасны дагуу цагдаа, дотоодын цэргийн 10495 алба хаагчдын албаны үнэмлэх, энгэрийн тэмдгийг шинэчлэн болон шинээр олгон.

Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлөөс зохион байгуулсан цагдаа, дотоодын цэргийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнийг сонгон шалгаруулах мэргэшлийн шалгалтад тэнцэж, нөөцөд бүртгэгдсэн иргэдээс мэдэгдлээр 268, тушаалаар 189, нийт 457 иргэнийг томилж, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын бага цолны албан тушаалд ажиллаж байгаа 153 алба хаагчийг шилжүүлэн ажиллуулах зөвшөөрлийг зохих журмын дагуу олгосон.

Соён гэгээрүүлэх, албаны сургалтын чиглэлээр: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны Б/257 дугаар тушаалаар “Сургалт арга зүйн зөвлөл”-ийг байгуулж, 2018 оны Б/08 дугаар тушаалаар “Цагдаагийн байгууллагын 2018 оны сургалтын төлөвлөгөө”, А/01 дүгээр тушаалаар “Цагдаагийн байгууллагын 2018-2019 оны явцад цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2018 оны соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-г баталж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын хэмжээнд удирдах ажилтны 56 удаагийн сургалтад 371, албан тушаалын 76 удаагийн сургалтад 245, гадаадын 40 удаагийн сургалтад 101, давтан 31 удаагийн сургалтад 763, мэргэшүүлэх 11 удаагийн сургалтад 204, ур чадварын 26 удаагийн сургалтад 456, бүсчилсэн 2 удаагийн сургалтад 2895, дадлагын 4 удаагийн сургалтад 5402, давхардсан тоогоор албаны 6105 удаагийн сургалтад 386245 алба хаагч, олон нийтийн цагдаа, иргэдэд зориулсан галт зэвсгийн 66 удаагийн сургалтад 1031 иргэнийг хамруулсан.

Тухайлбал шинээр батлагдсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр 680 удаагийн сургалтад 45095, алба хаагчийг мэргэшүүлэх чиглэлээр 1455 удаагийн сургалтад 50708, бие бялдрын бэлтгэлжилтийг хангах чиглэлээр 963 удаагийн сургалтад 36699 алба хаагчийг хамруулаад байна.

Нийт зохион байгуулагдсан сургалтын 2177 танхимаар, 844 дадлагаар, 116 зайны сургалтаар, 77 бүсчилсэн хэлбэрээр, 162 хээрийн дадлагаар, 425 удаа бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлж, 2958 хөтөлбөр, төлөвлөгөө, 409 сургалтын аудио, видео, бичлэг кино, 1894 сургалтын материал, бодлого, аргачлал тус тус боловсруулж, 5.3 сая төгрөгийг сургалтын зардалд зарцуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны А/221 дүгээр тушаалаар Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны харьяа Нийтийн хэв журам хамгаалах тасгийн, А/222 дугаар тушаалаар Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны харьяа Шуурхай удирдлагын тасгийн, А/228 дугаар тушаалаар Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын харьяа Замын цагдаагийн хэлтэс, тасгийн дарга нарын сургалт, зөвлөгөөнийг тус тус батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, үр дүнг тооцсон.

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр: Монгол Улсад суугаа гадаад орнуудын Элчин сайдын яамд, дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, айлчлал хийх, зохион байгуулах, мэндчилгээ дэвшүүлэх, судалгаа, мэдээлэл хүргүүлэх, мэдээлэл хүсэх, солилцох зэргээр хамтран ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд БНСУ, БНХАУ, АНУ, Хойд Судан, Дани, Швед, Катар, Тайланд, Индонези, ХБНГУ, БНЭУ, БНТУ, БНСВУ, Япон, Австрали, ХБНАБ Улс зэрэг 18 улсад зохион байгуулагдсан 31 удаагийн сургалт, семинарт 60 алба хаагчийг хамруулсан ба Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний цагдаагийн газраас Монгол Улсын цагдаагийн байгууллагын алба хаагчдад энэ оны 06 дугаар сард “Кибер гэмт хэрэгтэй тэмцэх нь” сэдэвт сургалтыг Монгол Улсад зохион байгуулж, 32 алба хаагчийг хамруулсан.

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, Израиль Улсын Нийгмийг аюулаас хамгаалах яам хооронд байгуулах харилцан ойлголцлын санамж бичгийн төсөл боловсруулах ажлын хүрээнд тус яамны Төрийн нарийн бичгийн дарга, Израиль Улсаас Бүгд

Найрамдах Хятад Ард Улсад суугаа Элчин сайдын яамны Монгол Улсыг хариуцсан зөвлөх хатагтай Руниэ Армасан нарын уулзалтад оролцож, санал солилцсон.

Гадаад улс, орнуудад зохион байгуулагдсан сургалт, семинартай холбоотой 31 удаагийн арга хэмжээнд 60, айлчлал, албан томилолт, үзэсгэлэн, тэмцээнд оролцохтой холбоотой 27 арга хэмжээнд 47, олон улсын хурал, уулзалтад оролцохтой холбоотой 10 арга хэмжээнд 14, энхийг сахиулах ажиллагаанд 4, нийт 69 арга хэмжээнд 125 алба хаагчийг гадаад томилолтоор ажиллуулж, үр дүнг тооцсон.

Үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр: Хууль зүй, дотоод хэргийн яаманд байгуулагдсан Согтуурах, мансуурах донтой хүнийг албадан эмчлэх тухай, Тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өмгөөллийн тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэгт цагдаагийн байгууллагын алба хаагчид ажиллаж байгаа бөгөөд тус яамнаас санал авахаар ирүүлсэн 29 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас саналыг авч нэгтгэн хүргүүлсэн.

Мөн Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа хүндрэл, бэрхшээл, нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай зохицуулалтыг алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас гаргасан саналыг нэгтгэн Хууль, зүй дотоод хэргийн яаманд хүргүүлээд байна.

Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 114 гомдол, санал, 12 нууцын зэрэглэлтэй албан бичгийн эрх зүйн зохицуулалтыг судалж, хууль зүйн зөвлөгөө, эрх зүйн дүгнэлт өгч, туслалцаа үзүүлсэн.

Тайлангийн хугацаанд эрүү, иргэн, захиргааны 20 хэрэгт хариуцагч, нэхэмжлэгчийн төлөөлөгчөөр оролцон, хариу тайлбар, нэхэмжлэл, нотлох баримт хүргүүлж, 18 удаа давж заалдах болон хяналтын гомдол бичгээр гаргаж, шүүхээр шийдвэрлүүлсэн ба хамтран ажиллах гэрээ 24, ажил гүйцэтгүүлэх гэрээ, бусад гэрээ 21, гадаад болон дотоодын байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг, хэлэлцээрийн 18 төслийг тус тус хянаж, хууль зүйн дүгнэлт гаргасан.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдын албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой 27 эрх зүйн актад нэмэлт, өөрчлөлт оруулан шинэчлэн боловсруулж, 18 эрх зүйн актыг тушаалаар баталгаажуулсан.

Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн сайдын батлах тогтоол, тушаалын төсөлд санал өгч, 17 шийдвэрийг баталгаажуулж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Дотоодын цэргийн үйл ажиллагааны 5 бүлэг, 59 журмын төсөл дээр ажиллаж байгаа ба “Улсын онц чухал объектын хамгаалалтын үйл ажиллагааны стандарт” /CS 11-0397 : 2018/-ыг Дотоодын цэргийн командлагчийн 2018 оны А/01 дүгээр тушаалаар батлуулсан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын дөрөв дэх эмхэтгэлийг гарган, 500 ширхгийг хэвлэж, алба, нэгжид хүргүүлсэн ба техник, технологийн хөгжил, дэвшлийг үйл ажиллагаандаа ашиглах зорилгоор “Police code” гар утасны апплейкешн буюу програм дээр журмыг байршуулж, алба хаагчид PU код, нууц үгээр нэвтрэн, гар утаснаас ашиглах боломжийг бүрдүүлсэн.

Мөн “system.police.gov” сүлжээнд Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг, “police.gov.mn” цахим хуудсанд “Цагдаагийн байгууллагад ажиллах иргэнд тавигдах тусгай шаардлага, шалгуур үзүүлэлт тооцох журам”, “Иргэний болон харуул, хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтын заавар”-ыг шинэчлэн байршуулсан.

Төрийн болон албаны нууц хадгалах, хамгаалах чиглэлээр: Хууль зүй, дотоод хэргийн сайдын энэ оны А/70 дугаар тушаалаар Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын

албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны А/123 дугаар тушаалаар Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны Төрийн болон албаны нууцыг хамгаалах /код 114/ журам, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэлтэй танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалт, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын нууц баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын бүрэлдэхүүнийг, А/207 дугаар “Журам шинэчлэн батлах тухай” тушаалаар цагдаагийн ерөнхий газрын төв байрны дотоод журмыг шинэчлэн тус тус баталж, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хүргүүлэн, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Цагдаагийн ерөнхий газрын төв байрны орчимд болзошгүй нөхцөл байдал үүссэн үед хамгаалалт хийх төлөвлөгөө, төв байрнаас нүүлгэн шилжүүлэх баримт бичиг, эд зүйлсийн жагсаалт, төв байрны алба, газар, хэлтсийн алба хаагчдын албаны бэлэн байдлыг хангаж, өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах төлөвлөгөө, бэлэн байдлын схемийг шинэчлэн баталгаажуулсан.

Эрүүгийн цагдаа, Хэрэг бүртгэх, Тээврийн цагдаагийн албад, Нийслэлийн цагдаагийн Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Эрүүл, хамгаалалтын газар, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газар, Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтэс, Дотоодын цэргийн 05, 805 дугаар анги, Багануур, Багахангай, Налайх дүүрэг дэх Дотоодын цэргийн тусгай салаад, Дотоодын цэргийн штабын Харуул, хамгаалалтын хэлтсийн нууц хамгаалах ажилтан, нууцын бичээч, Төв архивын тусгай сангийн тусгай архивчийн орон тоон дээр алба хаагчдыг судалж, Тагнуулын ерөнхий газрын холбогдох нэгжээр аюулгүй байдлын шалгалт хийлгэн, томилуулах зөвшөөрлийг гаргуулж, тус тусын алба, нэгжид томилсон.

Эрсдэлийн удирдлага, дотоод аудит, хяналт шалгалтын чиглэлээр: Цагдаагийн байгууллагын 2017 оны эрсдэлийн үнэлгээний тайланг гаргаж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд энэ оны нэгдүгээр улиралд хүргүүлсэн.

Цагдаагийн байгууллагаас 2018 онд хэрэгжүүлэх дотоод аудитын болон хяналт шалгалтын, эрсдэлд суурилсан дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөө /2018-2020/, төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн шалгалтын төлөвлөгөөг баталж, хуваарийн дагуу Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтэс, Сэлэнгэ, Дорнод, Баян-Өлгий, Завхан, Завхан аймаг дахь цагдаагийн газрын Тосонцэнгэл сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс, Дорноговь, Дорноговь аймаг дахь цагдаагийн газрын Замын-Үүд сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс, Өвөрхангай, Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газрын Хархорин сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс, Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газарт төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн, Ховд аймаг дахь цагдаагийн газрын үйл ажиллагаанд хэсэгчилсэн шалгалтыг тус тус зохион байгуулж, дүнг үндэслэн дээрх нэгжүүдэд ажлын чиглэл, зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй “Эрүүл” дэд хөтөлбөрийн хэрэгжилт, зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, удирдлагаас өгсөн үүрэг, ажлын чиглэл, ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилт, Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Төв архивын сан хөмрөгийг цахим хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаанд дотоод аудит, Цагдаагийн ерөнхий газар, Эрүүгийн цагдаагийн алба, Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газар, Дорноговь аймаг дахь цагдаагийн газрын Замын-Үүд сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан үйл ажиллагаанд санхүүгийн аудит хийж, холбогдох алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн үед жагсаал цуглааныг албадан тараах үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг энэ оны эхний хагас жилд хэрэгжүүлж, тайлан, зөвлөмжийг Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанд хүргүүлэн, хэрэгжүүлж байна.

Тайлангийн хугацаанд хэсгийн байцаагчийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх талаар 8, “Эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал” сэдвээр 8, “Цагдаагийн байгууллагын санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд гарч буй зөрчил, дутагдал, цаашид анхаарах асуудал” сэдвээр 1 удаагийн сургалтыг зохион байгуулж, алба хаагчдын ажилласан жил, тэтгэвэр дутуу тогтоогдох эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 төрлийн зөвлөмжийг боловсруулж, алба хаагчдад хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/130 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу 21 аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн үйл ажиллагаа, шинээр батлагдсан хууль тогтоомжуудын хэрэгжилттэй танилцан, мэргэшлийн түвшинг үнэлэх шалгалт, сургалтад 2964 алба хаагчийг хамруулж, дүнг Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн энэ оны 08 дугаар хуралдаанаар хэлэлцэж, хуралдаанаас гарсан шийдвэр, шалгалтын дүнтэй холбоотой үүрэг, ажлын чиглэлийг аймаг дахь цагдаагийн газар, хэлтэст хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр: Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх цагдаа, дотоодын цэргийн байгууллагын нэг дэх үе шатны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр 2017 онд зохион байгуулсан ажлын тайлан, нотломжийг загвар хүснэгтийн дагуу гаргаж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын албанд hutulbur@iaac.mn цахим хаягаар/, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг мэдүүлэх үүрэг бүхий 4326 албан тушаалтны 2017 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагад шинээр, шилжин болон дэвшин томилогдохоор нэр дэвшсэн 1154 алба хаагчийн материалыг Авлигатай тэмцэх газарт тус тус хүргүүлж, нэр дэвшсэн этгээдээс албан тушаалд томилогдсон 683 алба хаагчийн тушаал, шийдвэрийг мэдээллийн цахим бүрдүүлэлтийн санд бүртгэсэн.

Мөн Цагдаагийн байгууллагын авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөө, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2017 онд хэрэгжүүлсэн ажлын тайланг цагдаагийн байгууллагын www.police.gov.mn цахим хуудсанд байршуулж, иргэд, олон нийтэд хүргэсэн.

“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн 85 алба хаагчийн мэдэгдэл, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт заасны дагуу хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн 45 мэдүүлэг гаргагчийн мэдүүлгийг баталгаажуулсан.

Алба хаагчдад хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах талаар зааварчилга өгч, цахим сургалтын материал, нийтийн албан тушаалтнуудад зориулсан гарын авлага, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтанд зориулсан гарын авлага, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн хялбаршуулсан гарын авлагыг байгууллагын дотоод сүлжээнд байршуулж, судлуулсан.

Алба хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйн чиглэлээр: Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 12 бүлэг, 40 ажил, арга хэмжээг төлөвлөж, батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ оны эхний 9 сарын байдлаар төлөвлөгөөний биелэлт 74.5 хувьтай байна.

Тайлангийн хугацаанд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдаас 880 сахилгын зөрчилд 887 алба хаагч холбогдсоны 504 буюу 56.9 хувийг офицер, 380 буюу 42.8 хувийг ахлагч, 3 буюу 0.3 хувийг энгийн алба хаагч эзэлж байна. Үүнийг өнгөрсөн оны мөн

үетэй харьцуулбал сахилгын зөрчил 5 буюу 0.6 хувиар, алба хаагч 83 буюу 7.5 хувиар тус тус өсчээ.

Нийт сахилгын зөрчлийн 320 буюу 36.4 хувь нь нийслэлд, 442 буюу 50.2 хувь нь орон нутагт, 118 буюу 13.4 хувь нь Дотоодын цэргийн штабын харьяа нэгжээс бүртгэгдэж, 108 алба хаагч сахилгын зөрчил давтан гаргажээ.

Үүнээс ажлын хариуцлага алдсан 232 буюу 20.9, ажил тасалсан 136 буюу 12.3, архидан согтуурсан 169 буюу 15.3, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль зөрчсөн 108 буюу 9.7, бусад хууль, тогтоомж зөрчсөн 56 буюу 5.0, цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм зөрчсөн 164 буюу 14.8, цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм зөрчсөн 53 буюу 7.9, үүрэг даалгавар үл биелүүлсэн 64 буюу 9.5, хээл хахууль, шан харамж авсан 2 буюу 0.3, бусад зөрчил 57 буюу 5.1 хувийг тус тус эзэлж байна.

Сахилгын зөрчилд холбогдсон алба хаагчдын 339 буюу 30.6 хувьд нь сануулах, 612 буюу 55.2 хувьд нь албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, 33 буюу 2.9 хувьд нь албан тушаал бууруулах, 22 буюу 1.3 хувьд нь цагдаагийн цол бууруулах, 102 буюу 9.2 хувьд нь цагдаагийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах сахилгын шийтгэлийг оногдуулсан байна.

Нийт сахилгын шийтгэлийн 12.8 хувийг Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар, 81.6 хувийг тухайн байгууллагын даргын тушаалаар, 5.8 хувийг бусад байгууллагын даргын тушаалаар тус тус оногдуулсан ба 78.2 хувийг дотоодын хяналтаар, 21.8 хувийг гадны хяналтаар илрүүлсэн.

Дотоод хяналтаар илрүүлсэн зөрчил урьд оны мөн үетэй харьцуулбал 0.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Иргэд, байгууллагаас цагдаа, дотоодын цэргийн алба хаагчтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар: Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 1191 өргөдөл, гомдол ирүүлж, 1308 алба хаагчийг холбогдуулан шалгасны 1055 буюу 80.7 хувийг офицер, 248 буюу 19.0 хувийг ахлагч, 5 буюу 0.4 хувийг энгийн алба хаагч эзэлж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10 нэгж буюу 0.8 хувиар өсчээ.

Нийт зөрчлийг төрлөөр нь авч үзвэл: 59 буюу 5.0 хувь нь хууль ёс, хүний эрх чөлөөг зөрчсөн, 132 буюу 11.1 хувь нь хэрэг материал дутуу шалгасан, 23 буюу 1.9 хувь нь хэргийн хугацаа хэтрүүлсэн, 34 буюу 2.9 хувь нь бусдыг чирэгдүүлж, танил тал харсан, 10 буюу 0.8 хувь нь хээл хахууль, шан харамж авсан, 259 буюу 21.7 хувь нь цагдаагийн алба хаагчийн харьцааны соёл, ёс зүй зөрчсөн, 81 буюу 6.8 хувь нь бусдыг зодож, эрх чөлөөнд нь халдсан, 247 буюу 20.7 хувь нь ажлын хариуцлага алдсан, 30 буюу 6.5 хувь нь архидан согтуурсан, 7 буюу 0.6 хувь нь өмч хөрөнгө үрэгдүүлсэн, 260 буюу 21.8 хувь нь Эрүүгийн хэрэг хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль, тогтоомж зөрчсөн, 49 буюу 4.0 хувь нь бусад зөрчлүүд эзэлж байна.

Нийт хүлээн авсан өргөдөл, гомдлын 92.5 хувийг 30 хоногт, 1.3 хувийг 30-60 хоногт, 1 буюу 0.1 хувийг 60-с дээш буюу хугацаа хэтэрч шийдвэрлэсэн ба 41 буюу 3.4 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэх саналтай шилжүүлж, 307 буюу 25.8 хувьд нь сахилгын шийтгэл оногдуулж, 769 буюу 64.6 хувь нь цагдаагийн алба хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй, 40 буюу 3.4 хувь нь нотлогдсон боловч хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн гэх үндэслэлээр хааж, 93 буюу 7.8 хувьд шалгалтын ажиллагааг үргэлжлүүлэн явуулж байна.

Тайлангийн хугацаанд Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл хүлээн авах 126 дугаарын утсанд 202 дуудлага мэдээлэл ирүүлсэн нь урд оны мөн үетэй харьцуулхад 4 нэгж буюу 2.5 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа ба дуудлага, мэдээллийн 34 нь талархал, 168 нь алба хаагчидтай холбоотой гомдол, мэдээлэл эзэлж, 161 мэдээллийг хуулийн хугацаанд шийдвэрлэн, гомдол гаргагчид хариу өгч, 7 мэдээллийг шалгаж байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар: Тайлангийн хугацаанд алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсийн албан тушаалтанд иргэд, байгууллагаас

9657 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2447 нэгжээр буюу 25.3 хувиар өсчээ.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 16 буюу 0.2 хувь нь санал, 9459 буюу 97.9 хувь нь өргөдөл, 182 буюу 1.9 хувь нь гомдол байна.

Санал, өргөдөл, гомдлыг утгаар нь авч үзвэл: 1019 буюу 10.6 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 202 буюу 2.1 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 1374 буюу 14.2 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 2429 буюу 25.2 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 600 буюу 6.2 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 4033 буюу 41.8 хувь нь бусад өргөдөл гомдол байна. Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 9417 буюу 97.5 хувийг шийдвэрлэж, 240 буюу 2.5 хувь нь ажиллагаанд байна.

Иргэдээс Засгийн газрын “Иргэд олон нийттэй харилцах төв”-д цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 243 санал хүсэлт, өргөдөл гомдол, талархал, шүүмжлэл ирүүлсний 65 буюу 26.7 хувь нь санал хүсэлт, 145 буюу 59.7 хувь нь гомдол, 29 буюу 12.0 хувь нь талархал, 4 буюу 1.6 хувь нь шүүмжлэл байгаа ба 233 буюу 95.7 хувийг шийдвэрлэж, 10 буюу 4.3 хувь нь ажиллагаанд байна. Хариу хүргүүлсэн байдлыг чанараар нь авч үзвэл 180 буюу 77.3 хувийг 5 хоногийн дотор, 53 буюу 22.7 хувийг 5-аас дээш хоногт шийдвэрлэсэн.

Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хэрэгжилтийн талаар

Цагдаагийн байгууллагаас хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажил, арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллаа.

2.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр: Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж байна.

Гэмт, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зарчим, чиглэл, зорилго зорилтыг тодорхойлон хэрэгжүүлэх ажлын хүрээнд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогын баримт бичиг, баримт бичгийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны А/177 дугаар тушаалаар баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагаас 2018 оны эхний 09 сард гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 818 /улсын хэмжээнд зохион байгуулсан 11, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсээс зохион байгуулсан 807/ нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, 2156 үзлэг шалгалтыг зохион байгуулж, үр дүнг тооцсон. Үүнд:

Бусдын өмчийг хулгайлах, архидан согтуурахтай тэмцэх, залилах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, цахим орчин дахь гэмт хэрэг, зөрчил, насанд хүрээгүй хүн гэмт хэрэгт холбогдох, өртөхөөс урьдчилан сэргийлэх, дээрх чиглэлээр иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, хариуцлагыг сайжруулах зорилгоор “Сэрэмжилье-Нэгдье”, “Хуулиа мөрдье-21”, “Хуулийн хэрэгжилт”, “Бяцхан зорчигч”, “Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл”, “Байгалиа хамгаалъя”, “Өсвөр үе, хүүхэд, залуусыг гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл”, “Хичээлийн шинэ жил”, “UNFRIEND хөдөлгөөн” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж, үр дүнг тооцсон.

Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний үйл ажиллагаанд хяналт тавих “Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ MNS:5274:2017” Монгол Улсын стандартын хэрэгжилтийг хангуулах үзлэг шалгалтыг энэ оны 01 дүгээр сарын 23-29-ний хооронд улсын хэмжээнд зохион байгуулж, 796 барьцаалан зээлдүүлэх газрыг хамруулан, зөвлөмж, албан мэдэгдэл хүргүүлж, үр дүнг тооцлоо.

Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дээд шатны байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн санал, танилцуулгыг үндэслэн Монгол Улсын Засгийн газар болон яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн

Төлөөлөгчдийн хурал, ГХУСАЗСЗ-ийн тогтоол 9, Засаг даргын захирамж 52, тушаал 15, хөтөлбөр 19, журам 6, бусад шийдвэр 45 тус тус гаргуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал:

Нийслэлийн цагдаагийн газраас Эргүүл, Камержуулалт-2, Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтсээс “Гэр бүлсэг-Налайх”, Баянхонгор аймаг дахь цагдаагийн газраас “Амар амгалан”, Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газраас “Архигүй Алтайчууд”, “Хүүхдэд ээлтэй орон нутаг”, “Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, Дорнод аймаг дахь цагдаагийн газраас “Архигүй Дорнодчууд”, “Согтуу жолоочтой хамтдаа тэмцье”, Дархан-Уул аймаг дахь цагдаагийн газраас “Архигүй Монгол хүн”, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газраас “Архидан согтуурал, мансуурал, донтолтоос урьдчилан сэргийлье”, “Амгалан хот Даланзадгад”, Дундговь аймаг дахь цагдаагийн газраас “Архидалтгүй Дундговь”, Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газраас “Архигүй Сүхбаатарчуудын төлөө”, Ховд аймаг дахь цагдаагийн газраас “Тайван амгалан Ховдчууд”, Орхон аймаг дахь цагдаагийн газраас “Хулгайгүй Эрдэнэт”, “Эзэнгүй айл”, Завхан аймаг дахь цагдаагийн газраас “Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь”, “Хүүхдэд ээлтэй орон нутаг”, Хэнтий аймаг дахь цагдаагийн газраас “Архидалтгүй Хэнтий”, “Бүх нийтийн эрх зүйн боловсрол”, Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газраас “Аюулгүй иргэн-Амар тайван Өвөрхангай” зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сангийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс тодорхой хөрөнгийг шийдвэрлүүлэн ажиллаж байна.

“Монгол улсад сүүлийн 3 жилд насанд хүрээгүй хүмүүсээс болон хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл” сэдэвт судалгааны ажлыг Хууль сахиулахын их сургуулийн дэргэдэх “Цагаан шонхор” төрийн бус байгууллагатай хамтран гүйцэтгэж, судалгааны дүнд тулгуурлан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлийг тодорхойлон ажиллаж байна.

Оюутан, залуучуудыг гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, тэдний идэвх санаачилгыг өрнүүлж, хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, харилцан мэдээ, мэдээлэл солилцох, гадаад орны тэргүүн туршлагыг нэвтрүүлэх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор “Жи Си Ай Монгол” Олон улсын байгууллагатай, Цагдаагийн албаны тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиуд болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулан үр дүнг тооцон ажиллаж байна.

Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сантай байгуулсан 2017-2021 онд хамтран ажиллах “Санамж бичиг”-ийн хүрээнд “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх” төслийг хэрэгжүүлж, “Гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийн цахим сан”-г шинээр бүрдүүлж, үйл ажиллагаандаа ашигласнаар гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийн дагуу ажиллаж буй цагдаагийн алба хаагч хүчирхийлэл үйлдэгчийн талаарх мэдээллийг урьдчилан мэдэх боломжийг бүрдүүлсэн.

Улсын хэмжээнд 2557 хяналтын камер /орон нутагт 1120, нийслэлд 1437/-ийг үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ ашиглаж байна.

Нийслэл хотод гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Камержуулалт-2” болзолт уралдааныг энэ оны 04 дүгээр сарын 01-нээс хоёр сарын хугацаатай зохион байгуулж, үр дүнг тооцсон.

Орон нутгийн гудамж талбайд үйлдэгдэж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өсөлтийг саармагжуулах, иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэх зорилгоор орон сууц, гэр хорооллын гудамж, гадна орчинг камержуулах бодлого баримталж, нутгийн Засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон холбогдох бусад байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, камержуулах төсөв, хөрөнгийг шийдүүлэх, холбогдох зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал:

Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газар нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд болон 101, 102, 103-ыг нэгтгэж, аймгийн Шуурхай удирдлагын төвийг байгуулахад шаардлагатай 642.8 сая төгрөгийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлж, хяналтын камерыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Баян-Өлгий аймаг дахь цагдаагийн газраас тухайн аймгийн төрийн байгууллагуудад ашиглагдаж байгаа 668 хяналтын камерын судалгааг гаргаж, "Google earth" цахим програмд байршуулж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажилд ашиглаж байгаа бөгөөд төрийн болон төрийн бус байгууллага төвлөрсөн Өлгий сумын 5 дугаар багийг хяналтын камерын бүс болгосон.

Увс аймгийн 4 суманд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 18.5 сая төгрөгийн өртөгтэй камерыг суурилуулан, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

"Мал хулгайлах, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээ, бүсийн аймгуудын хамтын ажиллагаа" сэдэвт сургалт, зөвлөгөөн, спортын цогцолбор тэмцээнийг хангайн бүс /Архангай, Булган, Баянхонгор, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл/-ийн цагдаагийн газрын 180 алба хаагчдын дунд батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, үр дүнг тооцсон.

2.2.Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр: Улсын хэмжээнд 351.1 тэрбум төгрөгийн хохиролтой, 11519 холбогдогчтой, 12468 гэмт хэргийг илрүүлж, мөрдөн байцаалтад шилжүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад илрүүлсэн хэрэг 2122 буюу 17, холбогдогч 2464 буюу 21.3 хувиар өсч, хохирол 389.3 тэрбум төгрөг буюу 64.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Эрэн сурвалжлах "ASAP" санд 28929 хүн, мал амьтан, эд зүйлийг, зарлан мэдээлснээс 14279 хүн, мал амьтан, эд зүйлийг олж тогтоон, сангийн гүйцэтгэл 49.3 хувьтай байна.

Иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй 27673 гомдол, мэдээлэл хүлээн авч бүртгэн, 15494 буюу 63 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 98 буюу 0.4 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, 2018 буюу 36.5 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 10063 гомдол, мэдээлэл ажиллагаанд шалгагдаж байна.

Монгол банкны Санхүүгийн мэдээллийн алба, Эрүүгийн цагдаагийн алба хооронд байгуулсан хамтран ажиллах "Санамж бичиг"-ийн хүрээнд цагдаагийн байгууллагад шалгагдаж байгаа мэдээлэл, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт санхүүгийн мэдээлэл авах Олон улсын хүсэлтийг БНХАУ, Сингапур, Турк, ОХУ, Тайланд, Малайз, Австри, Испани зэрэг 13 улсруу Эгмонтын шугамаар илгээсэн бөгөөд 2 хүсэлтэд хариу авсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын энэ оны А/126 дугаар "Хууль зүй, дотоод хэргийн сайдын нэрэмжит цагдаагийн байгууллагын шилдэг хэсгийн төлөөлөгч шалгаруулах арга хэмжээ" тушаалын дагуу нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын хэмжээнд зохион байгуулж байна.

Орон нутаг дамжин гэмт хэрэг үйлддэг сэжигтэй этгээд, бүлэг бөөгнөрлийг гүйцэтгэх ажлын хяналтад авах, тэдгээрийн үйлдэж буй гэмт хэргийг баримтжуулж, илрүүлэх, таслан зогсоох, эрүүгийн болон гүйцэтгэх ажлын нөхцөл байдлыг саармагжуулах зорилгоор "Маршрут", нийслэлийн хэмжээнд хууль бусаар мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхэлдэг болон бусдыг биеэ үнэлэхэд татан оролцуулж, орон байраар хангадаг, биеэ үнэлэхийг зохион байгуулдаг саун, массаж, шөнийн цэнгээний газрын үйл ажиллагааг шалгаж, хууль бус үйлдлийг таслан зогсоох, гэмт хэрэг үйлдэж болзошгүй сэжигтэй этгээд, бүлэг бөөгнөрөл үүсгэж байгаа нийтийн байр, зочид буудал, баар, цэнгээний газрыг гүйцэтгэх ажлын хяналтад авах зорилгоор "Хяналт-2", "Давалгаа", гэмт хэргийн замаар олдсон эд зүйлийг худалдан авч борлуулдаг, барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж /ломбард/, ченжүүдийг илрүүлэх, эрүүгийн хариуцлага хүлээлгэх зорилгоор "Мөнгө угаах гэмт хэрэг 2018", маш нууцын зэрэглэлтэй 2 нэгдсэн арга хэмжээг батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу тус тус зохион байгуулж, үр дүнг тооцлоо.

2.3.Мөрдөн байцаах албаны чиглэлээр: Тайлангийн хугацаанд иргэд, аж ахуй нэгж, албан тушаалтнаас ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй 18092, өмнөх оны үлдэгдэл 397 гомдол,

мэдээлэлд буюу нийт 18489 гомдол, мэдээлэлд мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 6157 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 11797 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 249 гомдол, мэдээллийг харьяаллын дагуу бусад газарт шилжүүлж нийт шалгасан гомдол, мэдээллийн 98.4 хувийг шийдвэрлэж, одоо 286 гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд шалгаж байна.

Хэрэг бүртгэлтийн 15775 хэргийн 4972 хэргийг хааж, 257 хэргийг бусад газарт харьяаллын дагуу шилжүүлж, 6576 хэрэгт яллагдагчийг татаж нийт шалгасан хэрэг бүртгэлтийн хэргийн 69,4 хувийг шийдвэрлэж, одоо 4823 хэрэг хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж байна.

Мөрдөн байцаалтын өмнөх оны үлдэгдэл 4513 хэрэг дээр шинээр 6576 хэрэг буюу нийт 11089 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаас 7536 холбогдогчтой, 6186 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай, 904 холбогдогчтой 2445 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай прокурорын хяналтад шилжүүлж, 1493 холбогдогчтой 1198 хэргийг бусад хэрэгт нэгтгэн нийт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан хэргийн 88,6 хувийг шийдвэрлэж, одоо 1260 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байна.

Гэмт хэргийн улмаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагад нийт 408.4 тэрбум төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 187.8 тэрбум төгрөг буюу нийт хохирлын 45,9 хувийг нөхөн төлүүлж, хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах болон хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээг хангах зорилгоор учирсан хохирлын 22.8 хувь буюу 93.1 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилсэн.

Хулгайлах гэмт хэргийн шийдвэрлэлтийг эрчимжүүлэх зорилгоор “Хулгайлах гэмт хэргийн шийдвэрлэлт-2018”, хэрэг бүртгэлтийн хэргийн шийдвэрлэлтийг эрчимжүүлэх зорилгоор “Хэрэг бүртгэлт-2018”, мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор “Мөнгө угаах гэмт хэрэг-2018”, эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргийн эзэн, холбогдогчийг тогтоох зорилгоор “Илрүүлэлт оргодол шийдвэрлэлт 2018” зэрэг нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцлоо.

2.4.Хэрэг бүртгэх албаны чиглэлээр: Цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэгт заасан гэмт хэргийг харьяалуулан шалгах болсонтой холбогдуулан энэ оны 02 дугаар сарын 01-ээс Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэгт заасан гэмт хэргийн шинжтэй 9412 гомдол мэдээлэл шалгаснаас 3331 буюу 35.3 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 132 буюу 1.4 хувийг нь харьяаллын дагуу шилжүүлж, 5385 буюу 57.2 хувьд нь хэрэг бүртгэлтийн, 356 буюу 3.7 хувьд нь мөрдөн байцаалтын хэрэг тус тус нээн, үлдэгдэл 208 гомдол мэдээлэл шалгагдаж байна.

Гэмт хэргийн улмаас учирсан 4.8 тэрбум төгрөгийн хохирлоос 3.7 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлэлт 76.9 хувьтай байна.

Хэрэг бүртгэх албаны хэмжээнд хуульд заасан үндэслэл журмын дагуу 8 яллагдагчид хилийн хориг тавьж, 45 яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан бөгөөд 12 яллагдагч цагдан хоригдож байна.

Улсын хэмжээнд оны эхний 09 сарын байдлаар 28550 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 7252 буюу 25.4 хувийг “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” эзэлж байна. Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэгт заасан бүртгэгдэх үедээ гэмт хэрэг үйлдсэн этгээд нь тогтоогдоогүй нийт 6626 хэрэг бүртгэлтийн хэргээс 3721 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 56.1 хувьд хүрсэн нь өмнөх сараас 2.5, энэ оны нэгдүгээр сараас 42.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Тус албанаас хуулиар харьяалуулсан гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хэргийн шийдвэрлэлтийг ахиулах зорилгоор “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт хэлэлцүүлэг, “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд инноваци ашиглах нь” сэдэвт онол практикийн бага хурал, “Илрүүлэлт, эрэн сурвалжлалт, шийдвэрлэлт”, “Илрүүлэлт, шийдвэрлэлтийг эрчимжүүлэх-2018”, “Хэрэг бүртгэлт-2018” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцсон.

2.5.Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Тайлангийн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргээс гудамж талбайд 6156 бүртгэгдсэн нь 34.4 хувиар, олон нийтийн газарт 4056 бүртгэгдсэн нь 27.4 хувиар тус тус өсч, согтуугаар үйлдэгдсэн 2199 бүртгэгдсэн нь 938 нэгж буюу 29.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Тус албаны Нийтийн хэв журам хамгаалах газраас улсын хэмжээнд 145475 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас 52.574 буюу 36.1 хувь нь гэмт хэргийн, 92901 буюу 63.8 хувь нь зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл байгаа ба нийт зөрчлийн 891020 буюу 74.1 хувь нь нийслэлд, 312341 буюу 25.9 хувь нь орон үйлдэгдэж, зөрчлийн улмаас иргэд байгууллагад 10.0 тэрбум төгрөгийн хохирол учирснаас 9.4 тэрбум буюу 89.0 хувийг нөхөн төлүүлсэн.

Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвтэй хамтран архи хэтрүүлэн хэрэглэгч иргэдийг үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах ажлыг тогтмол зохион байгуулж, архины албадан эмчилгээнд 272, сайн дурын эмчилгээнд 2591 иргэнийг хамруулж, тэдэнд архидан согтуурах, мансуурахын хор уршиг, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийж ажилласан.

Тайлангийн хугацаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ангиудаас ирүүлсэн хорихоос суллагдсан 109 хүний, 260 хуудас материалыг хүлээн авч, захиргааны хяналт тогтоон ажиллаж байна.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр улсын хэмжээнд зохион байгуулагдсан 2659 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтад давхардсан тоогоор 43656 алба хаагч, 18941 автомашинтай, 172999 цагийн, 123 удаагийн жагсаал, цуглааны үеийн олон нийтийн аюулгүй байдлыг хангах хамгаалалт зохицуулалтад давхардсан тоогоор 5443 цагдаагийн алба хаагч, 465 автомашинтай, 1538 цагийн үүргийг тус тус батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн.

Дипломат төлөөлөгчийн газар, улсын онц чухал объектуудын хамгаалалтыг батлагдсан орон тоо, хүч хэрэгслээр дүрэм, стандартын дагуу зохион байгуулж, объектуудад давхардсан тоогоор 59204 хүн, 10229 тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлж, хөдөлгөөнийг бүртгэн хяналт тавьж, холбогдох хуулийн дагуу шийдвэрлэсэн.

Улсын хэмжээнд эхний 9 сарын байдлаар Дорноговь аймгийн 7, Дундговь аймгийн 8, Булган аймгийн 6, Төв аймгийн 4, Өмнөговь аймгийн 2, Сүхбаатар аймгийн 3, Говьсүмбэр аймгийн 1, Орхон аймгийн 1, Дорнод аймгийн 1, Хэнтий аймгийн 1, Архангай аймгийн 6, Өвөрхангай аймгийн 5 сум, Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороонд 1, нийт 12 аймгийн 48 сум, 1 дүүрэгт шүлхий, мялзан өвчин гарч, давхардсан тоогоор 142 постонд 471 алба хаагч үүрэг гүйцэтгэсэн.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр эрүүгийн 5111, иргэний 5989, захиргааны 744, нийт 11844 шүүх хуралдаанд дэг журам сахиулж, шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамжийг хэрэгжүүлэн, 500 хүнийг албадан ирүүлж, цагдан хорих байрнаас шүүхийн байранд 2040 хүнийг хуяглан хүргэх ажиллагааг зохион байгуулж ажилласан.

2.6.Тээврийн цагдаагийн албаны чиглэлээр: Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 159 дүгээр тушаалаар Тээврийн цагдаагийн албаны зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсантай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны А/215 дугаар тушаалаар Тээврийн цагдаагийн албаны даргын дэргэдэх зөвлөх эрх бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг, А/241 дүгээр тушаалаар тус албаны таних тэмдэг, түүний тайлбарыг, Тээврийн цагдаагийн албаны даргын А/06 дугаар тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг тус тус баталгаажуулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Мөн Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын бүтэц, чиг үүргийг тодорхойлох журам /код-105/-д заасны дагуу тус албаны дүрэм, тус албанд харьяалагдах алба хаагчдын ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтын төслийг боловсруулж, Цагдаагийн ерөнхий газрын даргаар батлуулахаар ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд иргэд, байгууллагаас гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 55348 дуудлага, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 53839 зам тээврийн осол, хэргийн, 1490 төмөр замын аюултай бүс, зурвас газар болон төмөр замын байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн, 19 нисэх онгоцны буудлын аюултай бүс, зурвас газар болон харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн байна.

Дээрх дуудлага, мэдээллээс хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 412, захиргааны зөрчил 18779, төмөр замын аюултай бүс, зурвас газар болон төмөр замын байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг 47, захиргааны зөрчил 1443, нисэх онгоцны буудлын аюултай бүс, зурвас газар болон харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг 4, захиргааны зөрчил 15 тус тус бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 81 хүн нас барж, 331 хүн гэмтэж, иргэд, байгууллагад 1.2 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Үүнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дуудлага, мэдээлэл 5954 буюу 16.8, гэмт хэрэг 183 буюу 30.8, гэмтсэн хүн 137 буюу 29.3 хувиар тус тус буурч, нас барсан хүн 13 буюу 19.1, иргэд, байгууллагад учирсан хохирол 540.8 сая төгрөг буюу 34.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Тус албаны Замын цагдаагийн газраас Монгол Улсын Ерөнхийлөгч, Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон зочид төлөөлөгчид зорчих, олон нийтийг хамарсан жагсаал цуглаан, баяр наадмын үеийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр 1101 удаагийн хамгаалалтад давхардсан тоогоор 1999, Төмөр зам дахь цагдаагийн газраас 4 удаагийн хамгаалалтад давхардсан тоогоор 450, Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтсээс Монгол Улсын Ерөнхийлөгч, Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон зочид төлөөлөгчид зорчих үеийн 8 удаагийн хамгаалалтад давхардсан тоогоор 96 алба хаагч тус тус зөрчил дутагдалгүй үүрэг гүйцэтгэсэн.

Гудамж, замын хяналт шалгалтаар 1178107 зөрчил илрүүлснээс согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 24123 зөрчил байна. Зөрчлийн тухай хуулийн дагуу 1095461 зөрчилд 32.6 тэрбум төгрөгийн торгууль оногдуулж, 19300 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, 4420 жолоочийг шүүхийн шийдвэрээр баривчлах арга хэмжээ авч, гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 11.1 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн нь нийт хохирлын 81.2 хувийг эзэлж байна.

Тайлангийн хугацаанд “Сар шинэ-Аюулгүй тээвэр”, “Мотоциклын бүртгэл”, “Бяцхан зорчигч”, “Анхаарал хариуцлага-Эрсдэлгүй орчин”, “Оюутан тээвэр-2”, “Орон нутгийн зам-хөдөлгөөний соёл-2018” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж, арга хэмжээний хүрээнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, Зам, тээврийн сайдын 2012 оны 59 дүгээр тушаалаар батлагдсан “Авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын хэрэгжилтийг хангуулж, үр дүнг тооцсон.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яам, Нийслэлийн боловсролын газартай хамтран зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, осолд орж буй хүүхдүүдийн тоог бууруулах ажлын хүрээнд хүүхэд, эцэг эхчүүдэд замын хөдөлгөөнд буруу оролцсоны улмаас учрах аюул, хор хохирол болон түүнээс урьдчилан сэргийлэх арга замыг таниулсан бодит “Үзүүлэх сургалт”-ыг энэ оны 09 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулж, нийслэлийн 6 дүүргийн 1200 хүүхэд, тэдний эцэг эхчүүдийг хамруулсан.

Мөн намрын ургац хураалт, хадлан тэжээл тээвэрлэлтийн үеийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол, гэмт хэргийг бууруулах түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран “Ургац-2018” нэгдсэн арга хэмжээг энэ оны 9 дүгээр сарын 05-наас эхлэн зохион байгуулж байна.

Зам тээврийн осол, бусад гэмт хэрэгт холбогдуулан шалгахаар эрэн сурвалжлагдаж байсан 475 тээврийн хэрэгсэл, эрэн сурвалжлах ASAP сангаар эрэн сурвалжилж байсан 425 этгээдийг илрүүлж, холбогдох албадад шилжүүлсэн.

Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтсээс шинэ нисэх онгоцны буудал байгуулагдаж байгаатай холбогдуулан замын цагдаагийн хяналтын байрны зориулалтаар ашиглах 3х6 м² хэмжээтэй зөөврийн сууц, зорчигч үйлчилгээний талбайд нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хяналт тавих чиглэлээр ажиллах алба хаагчдын байрлах 35м², 39м² талбай бүхий цагдаагийн байрыг Иргэний нисэхийн ерөнхий газарт хүсэлт гарган шийдвэрлүүлсэн.

Төмөр зам дахь цагдаагийн газраас Улаанбаатар төмөр замын удирдах газар, Зорчигч үйлчилгээний төв буудал, Тасалбарын төв, Улаанбаатар өртөө, Дохиолол холбооны хоёрдугаар анги, Хүүхдийн сектор, Толгойт өртөө, Ачиж буулгах экспедицсэн механикжсан анги, Төв эмнэлэг, Вагон депо, 179 дүгээр цэцэрлэг, Улаанбаатар худалдааны төв, Олон улсын тээвэр зуучийн төв, Дуу бүжгийн чуулга зэрэг 32 байгууллагад гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт сурталчилгаа зохион байгуулж, мэргэжил, арга зүйн зааварчилга өгч, дээрх байгууллагуудтай хамтарсан эргүүл шалгалтын ажлыг тогтмол зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллаж байна.

2.7.Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын чиглэлээр: Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 159 дүгээр тушаалаар Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсантай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны А/226 дугаар тушаалаар Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны даргын дэргэдэх зөвлөх эрх бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын бүтэц, чиг үүргийг тодорхойлох журам /код-105/”-д заасны дагуу тус албанд харьяалагдах алба хаагчдын ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтын төслийг боловсруулж, Цагдаагийн ерөнхий газрын даргаар батлуулахаар ажиллаж байна.

Статистик, мэдээллийн талаар: “Монгол Улс дахь 2017 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал” 6 бүлэг, 240 нүүр бүхий товхимлыг бэлтгэн 250 ширхгийг хэвлүүлж, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хүргүүлж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Гэмт хэрэг, зөрчлийн 7 хоногийн тойм мэдээ, баяр, амралтын өдрүүдийн эрүү, хэв журмын болон цаг үеийн нөхцөл байдлын мэдээлэл, танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий сайдад 30, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргад 37, Хууль зүй, дотоод хэргийн сайдад 31, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт 6, Улсын Их Хурлын гишүүнд 1, нийт 104-ийг боловсруулж, хүргүүлсэн.

Эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 323 хуулийн этгээд, 2109 иргэний гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа эсэхийг цагдаагийн байгууллагын мэдээллийн сангаас, ялтай эсэхийг лавлагааны сангаас гаргуулан тогтоосон хугацаанд хүргүүлсэн.

Ял шийтгэлийн сангаас лавлагаа авахаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн албан бичиг, иргэдийн хүсэлтээр 97821 лавлагааг олгосон ба төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу цагдаагийн байгууллагын мэдээллийн сангаас 147 төрлийн мэдээлэл, судалгааг гаргаж хүргүүлсэн.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн талаар: Нийт 145475 гомдол, мэдээлэл бүртгэгдэн шалгагдсанаас гэмт хэргийн шинжтэй 51690, зөрчлийн шинжтэй 92178, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллээс 32676 буюу 63.2 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 18642 буюу 36.1 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзан, 372 буюу 0.7 хувийг нь харьяаллын дагуу шилжүүлсэн.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 50410 буюу 97.5 хувийг 5 хоногт, 1280 буюу 2.5 хувийг 6, түүнээс дээш хоногт шийдвэрлэсэн.

Улсын хэмжээнд 28550, нийслэл хотод 72.7 хувь буюу 20525, орон нутагт 28.0 хувь буюу 7984, бусад газар /хилийн чанадад үйлдэгдсэн/ 0.1 хувь буюу 41 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад нийт хэрэг 5506 буюу 23.9, нийслэлийн хэмжээнд 5323

буюу 35.0, орон нутгийн хэмжээнд 167 буюу 2.1, бусад газар /хилийн чанадад/-ын хэмжээнд 16 буюу 64.0 хувиар тус тус өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл: Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 7252, Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 180, Хүчиндэх 419, Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 93, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 17888, Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг 217, Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг 121, Хүрээлэн байгаа орчны эсрэг 292 тус тус бүртгэгдэж урьд оны мөн үетэй харьцуулахад 4.3-86.0 хувь, Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 67, Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 31, Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг 15 тус тус бүртгэгдэж, 3.0-13.4 дахин өссөн, Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 614, Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 465, Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг 6, Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 210, Авлигын эсрэг гэмт хэрэг 26, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 204, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 997 бүртгэгдэж, 4.1-79.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Улсын хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 29.0, нийслэлд 22.7, орон нутагт 47.4 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс улсын хэмжээнд 4.0, нийслэлд хотод 6. нэгжээр тус тус буурч, орон нутагт 5.1 нэгжээр өссөн байна.

Гэмт хэргийн улмаас 43 хуулийн этгээд, 24753 иргэн хохирч, үүнээс 728 хүн нас барж, 6756 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 265 буюу 26.7 хувиар, гэмтсэн хүн 888 буюу 11.6 хувиар тус тус буурсан байна. Гэмт хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан 131912.8 сая төгрөгийн хохирлын 23958.4 сая төгрөг буюу 18.2 хувийг нөхөн төлүүлж, 4098.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн захиргааны зөрчлийн талаар: Нийт 1203361 захиргааны зөрчил бүртгэгдсэн ба 1194174 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 214527 буюу 21.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт зөрчлийн 891020 буюу 74.0 хувь нь нийслэлд, 312341 буюу 26.0 хувь нь орон нутагт бүртгэгджээ.

Зөрчил гаргасан 1166640 иргэн, 270 хуулийн этгээдийг 36.2 тэрбум төгрөгөөр торгох, мөн 19300 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 7964 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 1185870 буюу 99.3 хувьд цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч, 8304 буюу 0.7 хувьд шүүгч шийтгэл оногдуулсан байна.

Тайлангийн хугацаанд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн үедээ, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 61408 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1062 буюу 1.7 хувиар буурчээ.

Мэдээллийн технологи, харилцаа холбооны чиглэлээр: Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй дуудлага мэдээллийг бүртгэх, хохирогч, хохирол, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээд, бусад нэмэлт мэдээллээр дуудлага мэдээллийг баяжуулах, мэдээллийг хянаж баталгаажуулах, баталгаажсан мэдээлэлтэй алба хаагчид хүснэгт болон график хэлбэрээр танилцах боломж бүхий “Хоногийн мэдээ”, улсын онц чухал объектуудад гарсан зөрчил, харуул хамгаалалтын алба хаагчдаас гаргасан зөрчил, улсын онц чухал объектод нэвтрэх зөвшөөрөл авсан гадаадын иргэдийн мэдээллийг бүртгэлжүүлэх, “Гэрч, хохирогчийн хамгаалалтын бүртгэлийн програм хангамж”-уудыг шинээр боловсруулж, мэдээллийг бүртгэх, ашиглах боломжийг бүрдүүлсэн.

Цагдаагийн байгууллагын мэдээллийн системийг шинэчлэх ажлын хүрээнд хэрэг бүртгэлтийн хэргийн мэдээлэл бүртгэх хэсгийн хохирогч иргэн, байгууллага, холбогдогч иргэн, байгууллага, хохирол, сэргээсэн хэрэг, хугацаа сунгах, нэгтгэх, зүйлчлэл өөрчлөх, хохирол нөхөн төлөлт зэрэг цонхнуудын дэлгэцийн загварыг зурж, хэрэг шалгах ажлын төлөвлөгөөг програм хангамж боловсруулах чиглэлээр судалгаа хийж, дэлгэцийн загвар боловсруулах ажлыг эхлүүлсэн ба Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн

командлагчийн зөвлөлийн хурлын бүртгэлийн системийг боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

Цагдаагийн байгууллагын хоногийн мэдээний програм, хангамж боловсруулах ажлын хүрээнд Системд нэвтрэх, Хяналтын самбар, Нэгтгэгдсэн мэдээ, Ирүүлсэн мэдээлэл, Гэмт хэргийн шинжтэй бүртгэл, Нөхөн илрүүлэлтийн бүртгэлийн хэсэг, Жолооны үнэмлэхийн дугаар болон регистрийн дугаараар хайлт хийх хэсэг, Монгол Улсад суух гадаадын иргэний мэдээллийн хэсэг зэрэгт нэмэлт, өөрчлөлт, засвар хийж, үйл ажиллагаанд ашиглаж байна.

Монгол Улсын Их хурлын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний 5.4.9-д тусгагдсан “Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбайг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулах” бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хороо, “Мэдээлэл, холбооны сүлжээ” ТӨК, Эрчим хүчний яамны Цахилгааны газар, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж байна.

Гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг зарим гудамж, талбайг камержуулах төслийн судалгаа, тооцоо, танилцуулга боловсруулж, системийн ашиглалт, төлөвлөлт, өргөтгөл хийхтэй холбоотой зөвлөгөө, мэдээллийг тухайн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагаас Нэгдсэн хяналтын, удирдлагын төв, Улаанбаатар хот, аймгийн төвийн гудамж, талбайд камерын хяналтыг нэмэгдүүлэх тооцоо, судалгааг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсан ба БНХАУ-аас хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хийгдэх төсөл, ӨМӨЗО-ны буцалтгүй тусламжаар хийгдэх камержуулах төслийн материалуудыг орчуулж, салбарын яаманд хүргүүлээд байна.

Мэдээлэл хүлээн авах, шуурхай удирдлагын чиглэлээр: Энэ оны эхний 9 сарын байдлаар иргэд, байгууллагаас нийт 429575 дуудлага, мэдээллийг хүлээн авч, холбогдох газруудад дамжуулсан. Үүнд: Архидан согтуурсантай холбоотой дуудлага 63280, хэв журмын зөрчил 251855, гэмт хэргийн талаар 26664, сураггүй алга болсон хүний талаар 5629, олдсон хүүхэд /хүн/-ийн талаар 5966, гадаадын иргэнтэй холбоотой 821, хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 53719, цагдаагийн алба хаагчтай холбоотой 771, зам тээврийн ослын 77011 мэдээ мэдээлэл бүртгэгдсэн байна.

Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хамгаалах, холбогдох байгууллагад холбон зуучлах, дахин хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хүүхдийн 108 дугаарт хүүхдийн амь нас хохирсон болон хүүхдийн эрх зөрчигдсөн тухай 552 мэдээллийг дамжуулж, тус төвөөс 102 тусгай дугаарт ирүүлсэн 1137 дуудлагыг хүлээн авч хамтран ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн <http://102.police.gov> дотоод цахим хуудасны “МШУТ-ийн ШУХ 102 анхааруулж байна” хэсэгт хулгайлах гэмт хэргийн дуудлагын шийдвэрлэлтийн зөрчлийн талаар 67, гэр бүлийн хүчирхийллийн дуудлагыг олон давтамжтай ирүүлсэн утасны дугаар, хаягийн 198 мэдээллийг байршуулж, хяналт тавин ажиллаж байна.

2.8.Гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр: Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан “Биечилсэн хамгаалалтын арга хэмжээний заавар”-ыг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр урьдчилан сануулах хамгаалалтын 11, тодорхой үйлдлийг хязгаарлах 2, биечилсэн хамгаалалтын 6, мэдээллийн нууцлалыг хангах 1, тусгай техник, хэрэгслээр хангах 1, аюулгүй газарт түр байрлуулах 2, нийт 23 аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний хүрээнд шүүгч 1, гэрч 2, хохирогч 15, хамаарал бүхий этгээд 10, нийт 28 иргэний аюулгүй байдлыг хангасан.

Хамгаалалтад авагдсан гэрч, хохирогчдоос сэтгэл зүйн сорил авч, аюулын эрсдэлийн үнэлгээг хийн, сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх арга хэмжээг тухай бүр зохион байгуулан ажиллаж байна.

Хамгаалалтын арга хэмжээний хэлбэр, хамгаалалтад авагдсан хамгаалуулагч нарын дэлгэрэнгүй судалгааг гарган, урд хамгаалалтад авагдсан, дахин гэмт халдлага, заналхийлэлд өртөж болзошгүй нөхцөл байдлыг тодруулж, заналхийлэл үзүүлж болзошгүй этгээдүүдэд хяналт тавих чиглэлээр төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг хангаж байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын www.police.gov.mn цахим хуудас дахь “Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа” буланд 8 удаа, олон нийтийн цахим сүлжээ фейсбүүк дэх хэлтсийн хуудсаар 26 удаа мэдээлэл оруулж, сурталчилгааны богино хэмжээний кино /шторк/-г тус сүлжээний “Boost post” цэсийг ашиглан төлбөртэйгөөр 3205 хүнд хүргэж, үйл ажиллагаагаа сурталчлах ажлыг зохион байгууллаа.

2.9.Бүртгэл хяналтын чиглэлээр: Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургуулийн сонсогчдоос мэргэжлийн шалгалт авах он, сар, өдөр, сургууль, дамжааны нэр, шалгалт авах ангилал, байрлал зэрэг мэдээллийг багтаасан шалгалтын хуваарийг тус төвийн үйлчилгээний танхим болон www.facebook.com/licensepolice цахим хуудсанд байршуулж, холбогдох мэдээллээр ханган цахимаар шалгалт авах үйл ажиллагааг эхлүүлж, програмд гарч байгаа алдаа, дутагдлыг арилгах ажлыг шат дараалалтай хийж шалгалтыг жигдрүүлэх ажлыг зохион байгуулсан.

Тээврийн хэрэгсэл жолоодох эрх олгох шалгалтад тэнцсэн В ангиллын 40662, ВС ангиллын 1169, А ангиллын 4096, С ангиллын 10076, Д ангиллын 6117, Е ангиллын 7941, М ангиллын 2178 иргэний материалыг хүлээн авч, жолоочийн бүртгэлийн мэдээллийн /TPS/ нэгдсэн санд бүртгэн, тээврийн хэрэгслийн жолоодох эрхийн үнэмлэхийг шинээр олгосон.

Хууль зүйн сайдын 2015 оны А/189 дүгээр тушаалаар баталсан жолоодох эрхийн үнэмлэх олгох журмын дагуу 126748, олон улсын 753, гадаад үнэмлэх солилт, нөхөн олголтоор 3016, үнэмлэх солилтоор 6498, нөхөн олголтоор 46806 жолоочийн үнэмлэхийг тус тус хэвлэж олгосон.

Энэ хугацаанд Бүртгэл, хяналтын төвийн үйлчилгээний танхимаар 57942, Нийслэлийн нэг цэгийн үйлчилгээний /Дүнжингарав/ төвөөр 15036 иргэнд үйлчилж, Монгол шуудан ХК-иар дамжуулан 5701 захиалгын үйлчилгээ үзүүлж, нийт 85876 иргэнд үйлчилж ажиллаа.

Иргэдэд үйлчлэх танхимаар үйлчлүүлэхээр хүсэлт гаргасан иргэдээс Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм зөрчсөн болон цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах ASAP санд эрэн сурвалжлагдаж байгаа эсэхийг TPS санд шалган 1829 иргэний 192.7 сая төгрөгийн торгуулийг нөхөн төлүүлж, эрэн сурвалжлагдаж байсан 38 этгээдийг илрүүлж, холбогдох нэгжид хүлээлгэн өгсөн.

Хууль зүйн сайдын 2013 оны А/130 дугаар тушаалаар баталсан “Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих журам”-д зааснаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа байгууллагуудаас тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах нэмэгдэл ял шийтгэгдсэн 415 ялтны материалыг хүлээн авч, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй 17 ялтанд оногдуулсан эрх хасах нэмэгдэл ялыг жолоочийн мэдээллийн сан /TPS/-гийн хар жагсаалтад шинээр /жолоодох эрх олгохгүй байх төлөвөөр/ бүртгэж, 398 ялтны тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг мэдээллийн санд хасалт хийн, холбогдох байгууллагуудад мэдээллийг хүргүүлээ.

Улсын хэмжээнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх нь хасагдсан 19.713 иргэний мэдээллийг TPS санд бүртгэж, эрх сэргээх шалгалтад тэнцсэн 12.494 жолоочийн эрхийг сэргээж, зөрчлийн улмаас 277 иргэний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг түдгэлзүүлж, шүүх прокурор, дээд шатны байгууллагаас ирүүлсэн шийдвэрийн дагуу 32 иргэний жолоодох эрхийг хугацааны өмнө сэргээсэн.

Хууль зүйн сайдын 2015 оны А/186 дугаар тушаалаар баталсан Тээврийн хэрэгсэл жолоодох эрх дуусгавар болох, эрх сэргээх журмын дагуу Дүнжингарав худалдааны төв дахь Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд 17.389 иргэний жолоочийн эрх сэргээх шалгалтыг

цахим хэлбэрээр авснаас 7.059 иргэн шалгалтад тэнцэж, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг сэргээсэн.

Зөвшөөрөл, хяналтын чиглэлээр: Галт зэвсгийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт зааснаар худалдааны төвөөс галт зэвсэг худалдан авах хүсэлт гаргасан 133, галт зэвсэгтэй адилтах хэрэгсэл худалдан борлуулах төвөөс 10 аж ахуйн нэгжийн 37, улсын хилээр 2, гадаад орноос галт зэвсэг худалдан авах хүсэлт гаргасан 45, мөн хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар улсын хилээр галт зэвсэг нэвтрүүлэх зөвшөөрөл хүссэн 30, уралдаан тэмцээнд 4 байгууллагын 24 тамирчинд тус тус зөвшөөрөл олгосон.

Гэмт хэрэг, зөрчлийн улмаас нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хураагдсан 64 ширхэг галт зэвсгийг хүлээн авч, дугаарлан Цагдаагийн ерөнхий газрын галт зэвсгийн агуулахад байрлуулсан.

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 11, 12, 15 дугаар зүйлд заасны дагуу тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, худалдах, үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил, үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах санал авахаар хандсан 67 аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авч хянан, шаардлага хангасан 46 аж ахуйн нэгжийг дэмжих саналыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлж, шаардлага хангахгүй 14 аж ахуйн нэгжид татгалзсан тухай хариу өгсөн.

Мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх хүсэлт гаргасан 85 аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авч, 68 аж ахуйн нэгжийн 301 тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгон, 17 аж ахуйн нэгжийн 21 тээврийн хэрэгсэлд татгалзсан хариу хүргүүлж, 2 аж ахуйн нэгжийн хүсэлтийг шалгаж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/292 дугаар тушаал /тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх журам/-ын дагуу хугацаа дууссан болон шинээр зөвшөөрөл хүсч, ирүүлсэн 396 байгууллага, албан тушаалтны хүсэлт, холбогдох баримт бичгийг хянан, 250 байгууллага, албан тушаалтны 712 тээврийн хэрэгсэлд 3 сараас 1 жил хүртэлх хугацаагаар зөвшөөрөл (улаан 116, хөх 21, хөх-улаан 24, ногоон 160, Шар 391) олгосон.

Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлжүүлэх зорилгоор гэрээт харуул, хамгаалалтын байгууллагын бүртгэлийн нэгдсэн сангийн SAS /security agency services/ програм хангамжийг нэвтрүүлж, гэрээт харуул, хамгаалалтын 253 аж ахуйн нэгж, байгууллага /нийслэлд 233, орон нутагт 20/-ын мэдээллийг санд бүртгэн, үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна.

2.10.Архивын үйл ажиллагааны чиглэлээр: Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 269 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”, “Албан хэрэг хөтлөлтийн бүртгэл хяналтын програм”-ыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ашиглах, “Байгууллагын архивын үндсэн заавар”, “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт /MNS 5140:2011/”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Архив албан хэрэг хөтлөх /код 120/ журам”-ын хэрэгжилтийг хангах, “Able cloud” цахим системийг идэвхжүүлэх ажлыг зохион байгуулж, мэдээллийн урсгал, бичиг баримтын давхардал зэрэгт тавих хяналтыг сайжруулж, албан хэрэг хөтлөлтийн стандарт, журмыг хэрэгжүүлэн ажилласан.

Цагдаагийн байгууллагын төв архив нь 1928 иргэнд “Нэг цэгийн үйлчилгээ, иргэд хүлээж авах байр”-аар лавлагаа олгож, архивын 2 дугаар сангаас 1090, Хүний нөөц, сургалтын хэлтсээс 748, нийт 1838 боловсон хүчний хувийн хэрэг, материалыг ашиглаж, 748 хөмрөгийн 9868 боть хадгаламжийн нэгжийн 2155901 хуудас баримтад шүүлт хийн, захиалгаар 1987, албан бичгээр 871, өргөдлөөр 97 нийт 2955 архивын лавлагаа гаргуулах хүсэлт иргэд, байгууллагаас хүлээн авч лавлагааг гаргасан.

2.11.Хэвлэл, мэдээллийн чиглэлээр: Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

зохион байгуулж буй үйл ажиллагааг сурталчлах, иргэд, олон нийтэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ мэдээллийг түгээх ажлын хүрээнд МҮОНРТ-р бэлтгэн хүргэдэг “Амрыг эрье”, “Цагдаагийн мэдээлэл” нэвтрүүлгийг ETV, “Эх орон” телевизээр 126 нэвтрүүлгийг иргэд, олон нийтэд хүргэсэн. Тайлангийн хугацаанд www.police.gov.mn сайтад 397 мэдээ, мэдээлэл нийтлэгдсэн.

Хэвлэл мэдээллийн төвийн фэйсбүүк хуудаст 889 мэдээ, мэдээлэл нийтэлсэн нь давхардсан тоогоор 5,089,975 хүнд хүрсэн, 66,475 уншигчид “таалагдсан”, 13,959 хүн хуваалцсан, 5117 сэтгэгдэлтэй байна. Фэйсбүүк хуудас 75,481 дагагчтай, өдөрт дунджаар 62000 хүн хандаж мэдээлэл авдаг ба төвийн твиттер хаягт 235 мэдээ, мэдээллийг нийтэлж, 217,563 хүнд хүргэсэн байна.

Хэвлэл мэдээллийн төвөөс цаг үеийн нөхцөл байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 15 удаа хэвлэлийн хурал зохион байгуулж, давхардсан тоогоор 317 хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажилласан.

2.12.Зохион байгуулсан спорт, урлагийн арга хэмжээний чиглэлээр: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2018 оны спортын аварга шалгаруулах тэмцээний төрөл, нэгдсэн зааврыг батлах, зохион явуулах ажлын хэсэг байгуулах тухай” А/57 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд самбо бөх, сагсан бөмбөг, шатар, ширээний теннис, хүчний 3 төрөлт, хүндийн өргөлт, чөлөөт бөх, буудлага, жүдо бөх, дугуй, хөнгөн атлетик зэрэг 11 төрлийн тэмцээнийг амжилттай зохион байгуулж, давхардсан тоогоор 292 байгууллагын 1861 тамирчин, алба хаагч оролцсон.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөний төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааны дагуу гар бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, 12 багийн 150 удирдах ажилтныг хамруулсан.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн энэ оны Б/419 дүгээр “Тамирчдыг бэлтгэлд гаргах тухай” тушаалаар Тулгар төрийн 2227, Их Монгол Улсын 812, Ардын хувьсгалын 97 жилийн ой, Үндэсний их баяр наадмаар цагдаагийн байгууллагыг төлөөлөн үндэсний бөхийн барилдаанд барилдах 33, сурын харваанд оролцох 14 алба хаагч, тамирчдын бэлтгэлийг хангасан ба Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын харьяат, аймгийн хурц бадрангуй арслан, Цагдаагийн ерөнхий газрын “Хүч” спортын хорооны туслах дасгалжуулагч, цагдаагийн ахлагч Н.Золбоо 6 даван Монгол улсын “Харцага” цол хүртсэн.

Индонезийн нийслэл Жакарта хотноо зохион байгуулагдсан Азийн XVIII наадмын жүдо бөхийн төрөлд “Хүч” спорт хорооны дасгалжуулагч, цагдаагийн ахмад М.Уранцэцэг 48 кг жинд хүрэл, туслах дасгалжуулагч, цагдаагийн ахлах ахлагч Э.Бэхбаяр 57 кг жинд алт, буудлагын төрөлд туслах дасгалжуулагч, цагдаагийн ахлах ахлагч Г.Нандинзаяа урт бууны 10 метрийн төрөлд хүрэл, 50 метрийн гурван байдлаас буудах төрөлд алтан медаль хүртэж, чөлөөт бөхийн төрөлд дасгалжуулагч, цагдаагийн ахмад Н.Золбоо 120 кг жинд шагналт 7 дугаар байр, хүндийн өргөлтийн төрөлд ОУХМ, Эргүүл, хамгаалалтын газрын эргүүлийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Э.Мөнхдөл 62 кг жинд 9 дүгээр байр тус тус эзэлж, амжилттай оролцсон.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлаг, байгууллагуудын ажилтнуудын дунд уламжлал болгон зохион байгуулдаг спортын тэмцээн, Төрийн тусгай хамгаалалтын алба үүсэн байгуулагдсаны 80 жилийн ойн нэрэмжит үндэсний аюулгүй байдлын тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд зохион байгуулагдсан тэмцээнд багийн дүнгээр тус бүр III, Төрийн цэргийн болон Хууль сахиулах байгууллагуудын удирдах ажилтнуудын дунд зохион байгуулагдсан “Нөхөрсөг-уулзалт” тэмцээнд I байранд тус тус шалгарсан.

Цагдаагийн байгууллагын “Сүлд” чуулгаас “Үргэлж тантай хамтдаа” соён гэгээрүүлэх өдөрлөгийг зохион байгуулж, 15 газар, хэлтсийн 1832 алба хаагч, 3353 иргэд, оюутныг хамруулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг 22 аж ахуйн нэгжийн хамтын ажиллагааг сурталчлан, их, дээд, ерөнхий боловсролын сургуулийн оюутан, сурагчдад 9 удаагийн лекц, сургалтыг зохион байгуулсан.

Тайлангийн хугацаанд тус чуулгын уран бүтээлчид давхардсан тоогоор 393 удаагийн бүрэн болон хэсэгчилсэн тоглолтоор 48402 алба хаагч, иргэд, олон нийтэд үйлчилж, 87 шинэ уран бүтээлийг туурвисан байна.

Гурав. Санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний ажлын талаар

Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 21 аймаг, сум дундын 4 хэлтэс, нийслэлийн цагдаагийн газар болон харьяа 18 газар, хэлтсийн нийт 61 байгууллагаас санхүүгийн тайланг хүлээн авч, жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасны дагуу Үндэсний аудитын газарт хүргүүлэн, хянуулсан ба шалгалтаар зөрчил, дутагдал заагдаагүй.

Энэ онд цагдаа, дотоодын цэргийн 60 анги байгууллагын төсвийн урсгал санхүүжилтийн зардалд 163.7 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 19.9 тэрбум төгрөг нийт 183.6 тэрбум төгрөгийг баталсан ба үүний 111.4 тэрбум буюу 60.6 хувь нь цалингийн зардал, 2.5 тэрбум буюу 0.1 хувь нь ажил олгогчоос төлөх эрүүл мэндийн даатгалын зардал, 19.9 тэрбум буюу 10.8 хувь нь хөрөнгө оруулалтын зардал, 49.8 тэрбум буюу 27.1 хувь нь урсгал зардалд тус тус зарцуулахаар төлөвлөн, хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллаж байна.

Шилэн дансны тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор шилэн дансны нэгдсэн портал системийн цахим хуудас <http://www.shilendans.gov.mn> болон Цагдаагийн ерөнхий газрын www.police.gov.mn сайтад Санхүү, аж ахуйн алба, Цагдаагийн гэрээт хамгаалалтын албаны 2018 оны гуравдугаар улирлын төсөв, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт, бусад санхүүгийн мэдээлэл, аудитаар баталгаажсан санхүүгийн болон аудитын тайлан, аудитаар өгөгдсөн зөвлөмж, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг тогтоосон хугацаанд байршуулж, олон нийтэд ил тод мэдээлсэн.

Цагдаагийн албаны тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 74 дүгээр тогтоолын дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар аймгийн төвөөс бусад суманд 5-аас дээш жил ажилласан 103 алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшил, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон 207 алба хаагчид 36 сарын цалин, хөлстэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж, цэргийн алба хаасны тэтгэвэр хувь тэнцүүлэн тогтоолгосон 3 алба хаагчид 18 сарын цалин, хөлстэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн 3 алба хаагчид 18 сарын цалин, хөлстэй тэнцэх хэмжээний урьдчилгаа тэтгэмж, нас барсан 6 алба хаагчийн ар гэрт 36, 2 алба хаагчийн ар гэрт 60 сарын цалин, хөлстэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж тус тус олгохоор шийдвэрлэж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 6723 алба хаагчийг гэнэтийн ослын даатгалд хамруулан “МИГ даатгал” ХХК-тай, 835 тээврийн хэрэгслийн жолоочийг “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал”-д, 839 тээврийн хэрэгслийг “Тээврийн хэрэгслийн даатгал”-д хамруулан “Ард даатгал” ХХК-тай, 635 объект, 21 тоног, төхөөрөмжийг “Үл хөдлөх хөрөнгийн даатгал”-д хамруулан “Практикал даатгал” ХХК-тай тус тус гэрээ байгуулан ажиллаж байна.

Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр Төрийн албаны тухай хуулийн хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2004 оны 112 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид тусламж олгох нөхцөл, журам”-ын 5 дугаар зүйлийн “в”-д заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын болон Санхүү, аж ахуйн албаны даргын тушаалаар цагдаагийн төв байгууллага, харьяа нэгжийн 48 алба хаагч, ажилтны ар гэрт 5.7 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, нас барсан 13 алба хаагчийн ар гэрт 13 сая төгрөгийн оршуулгын зардлыг тус тус олгосон.

Цагдаагийн ерөнхий газар, ХААН банкттай 2018-2019 онд хамтран ажиллах гэрээнд цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны цалингийн зээлийн хүүг 0.2, орон сууцны зээлийн хүүг 0.1 хувиар тус тус бууруулж, олгохоор тусгаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Алба, нэгж нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас алба хаагч, ажилтныг зах зээлийн үнээс хямд орон сууцаар хангах ажлын хүрээнд Баянзүрх дүүргийн 10 дугаар хороонд /Цагдаа хотхон-Амгалан/ 180 айлын нэгдүгээр ээлжийн, Багануур дүүргийн 3 дугаар хороонд 36 айлын орон сууцыг ашиглалтад оруулж, Баянзүрх дүүргийн 8 дугаар хороонд /Хууль сахиулагч-1 хотхон/ 260 айлын, 10 дугаар хороонд /Цагдаа хотхон-Амгалан/ 180 айлын хоёрдугаар ээлжийн, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 8 дугаар багт 40 айлын орон сууцны барилгын ажил тус тус явагдаж байна.

Улсын төсвийн хөрөнгө, оруулалтаар Цагдаагийн ерөнхий газрын “Сүүж-Уул” амралт, сэргээн засах сувиллын байранд 360.0 сая төгрөгийн их засварын ажлыг гүйцэтгэж, алба хаагч, ажилтан, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн ая тухтай амарч, эмчлүүлж, сувилуулах нөхцөл боломжийг бүрдүүлсэн.

Алба хаагч, ажилтны ажиллах нөхцөл боломжийг сайжруулах зорилгоор улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Архангай аймаг дахь цагдаагийн газар, Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтэс, Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газрын Сайхан сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс, Хэрэг бүртгэх алба, “Сүлд” чуулга, Дотоодын цэргийн 805 дугаар ангийн ажлын байранд их болон урсгал завсар хийж, гүйцэтгэлийг хангасан. Мөн орон нутгийн замын цагдаагийн хяналтын 27 пост, Мөрдөн байцаах албаны барилга барих ажлыг хэрэгжүүлж, 13 постын барилгыг хүлээн авч, 14 постын барилгын гүйцэтгэл 75-95 хувьтай, Мөрдөн байцаах албаны барилгын гүйцэтгэл 80 хувьтай, барилгын ажил явагдаж байна.

Нийслэлийн цагдаагийн газраас Ар гүнт дэх Шар хадны аманд 16 алба хаагчдад, Налайх дүүргийн нутаг дэвсгэр Тэрэлжийн аманд 19 алба хаагчдад зуслангийн газар эзэмших эрхийг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлсэн.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 65 алба, газар, хэлтсийн 9382 алба хаагчдад нэрийн дүрэмт хувцас чимэг хэрэглэлийн 55197 нэгдсэн, 1574 алба хаагчдад 6295 баримт, 48 алба хаагчдад 64 захиалгын хуудсан хангалтыг хийж, олгосон.

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын дүрэмт хувцасны дэлгүүрийн үйл ажиллагааг энэ оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс эхлүүлж, 46 нэр төрлийн дүрэмт хувцас, чимэг хэрэглэл, 9 нэр төрлийн бэлэг дурсгалын, 5 нэр төрлийн хэвлэмэл бараа бүтээгдэхүүнийг алба хаагчдад худалдаж, 21.0 сая төгрөгийн орлоготой ажилласан.

Монгол Улсын “Генералуудын өдөр”-ийг тохиолдуулан цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас төрөн гарсан генерал цолтнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний бэлтгэл ажлыг хангаж, 9 генерал цолтонд 20.7 сая төгрөгийн өртөг бүхий 3 нэр төрлийн дүрэмт хувцсыг дурсгасан.

Дөрөв. Дотоодын цэргийн штабын үйл ажиллагааны талаар

Улсын Их Хурлын 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж буй Дотоодын цэргийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2018 онд дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн өгсөн үүрэг, ажлын чиглэлийг өдөр тутмын үйл ажиллагаандаа удирдлага болгон, Дотоодын цэргийн штабын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2018 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг тус тус баталж, биелэлт үр дүнг эхний 9 сарын байдлаар тооцон, ажиллаж байна.

Дотоодын цэргийн штабын даргын 2018 оны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг баталж, 13 удаагийн хуралдаанаар удирдлага зохион байгуулалтын 15, хүний нөөцийн 163, албаны шалгалтын дүнгийн 15, нийт 193 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар Тусгай хэрэгсэл, галт зэвсэг тусгай зориулалтын техникийн төрөл батлах тухай, Дотоодын цэргийн алба хаагчийн хэрэглэх тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг, сумыг бүртгэх, олгох, буцаан авах, хадгалах журам батлах тухай, Дотоодын цэргийн алба хаагч чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай биеийн хүч, тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх, бэлтгэл хангах журам батлах тухай,

Дотоодын цэрэг чиг үүргээ хэрэгжүүлэхэд хэрэглэх тусгай хэрэгсэл, галт зэвсэг, тусгай зориулалтын техникийг хэрэглэх заавар батлах тухай, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын нарын Галт зэвсгийг түгшүүрийн дохио өгөх, тусламж дуудах, бэлтгэл, сургуулилтын болон хуульд заасан бусад тохиолдолд хэрэглэх заавар батлах тухай, Дотоодын цэргийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ хүнийг түр саатуулах заавар батлах тухай, Дотоодын цэргийн командлагчийн Орон тоо нэмж батлах тухай, Тусгай салбар байгуулах, орон тоо батлах тухай зэрэг 8 эрх зүйн актыг боловсруулан батлуулж, үйл ажиллагаанд мөрдөж байна.

Улсын онц чухал объектын хамгаалалтын чиглэлээр: Засгийн газрын 2017 оны 281 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, дотоодын цэргийн хамгаалалтад байгаа улсын онц чухал объектуудын хамгаалалтыг батлагдсан орон тооны хүч хэрэгслээр дүрэм, стандартын дагуу зохион байгуулж, объектуудад давхардсан тоогоор 743.626 ажилчин, 178.572 иргэн, 3.232 гадаадын иргэн, 169.937 тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлж, 327.026 хөдөлгөөнийг бүртгэн хяналт тавьж ажилласан.

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээврийн замд харгалзан хүргэх хамгаалалтын чиглэлээр: Дотоодын цэргийн тухай, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн холбогдох заалтын дагуу тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөлтэй 21 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, 8.928 тонн 11.724 кг тэсэрч дэлбэрэх бодис, 7.6 сая метр, 2.8 сая ширхэг тэсэлгээний хэрэгслийг 5 дүүрэг, 11 аймгийн 19 сумын нутаг дэвсгэрт хүргэх 538 удаагийн тээвэрлэлтийн хамгаалалтыг 588 алба хаагч төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэстэй хамтран гүйцэтгэж, аюулгүй байдлыг нь ханган, хяналт тавьж, хамгаалалтын төлбөр болох 71.8 сая төгрөгийг Цагдаагийн ерөнхий газрын гэрээтийн данс /Төв төрийн сан 900012048/-нд төвлөрүүлсэн.

Мөн Химийн хорт болон аюултай бодисыг тээврийн замд харгалзан хүргэх хамгаалалтыг зохион байгуулах түр гэрээг “Отгон уулын элч” ХХК-тай байгуулж, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “Толгойт өртөө”-ний гаалийн баталгаат талбайгаас 230 тонн “Цианит натри” бодисыг хамгаалалтад авч, Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутаг дэвсгэрт байрлах “Баян айраг экс плорэйшн” ХХК-ний уурхайн агуулахад аюулгүй байдлыг хангаж, тээврийн замд харгалзан хүргэх 2 удаагийн хамгаалалтын үүргийг 6 алба хаагч тусгай тоноглол бүхий хөтөч автомашинтайгаар Онцгой байдлын ерөнхий газрын аврах бүлэгтэй хамтран гүйцэтгэсэн.

Тав. Дүгнэлт

-Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас энэ оны эхний гуравдугаар улиралд хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг, 2018 онд цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаа.

-Улсын хэмжээнд 2018 оны гуравдугаар улиралд 28550 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт гэмт хэрэг 5506 нэгжээр буюу 23.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 71.9 хувь буюу 20525 нь нийслэлд үйлдэгдэж, 5323 буюу 71.9 хувиар өссөн сөрөг үзүүлэлттэй байна.¹

-Гэмт хэргийн илрүүлэлт 29.0 хувь, нийслэлд 22.7 хувь, орон нутагт 47.4 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс улсын хэмжээнд 4.0, нийслэлд 6.9 хувиар тус тус буурч, орон нутагт 5.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

-Тайлангийн хугацаанд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдаас гаргасан нийт сахилгын зөрчлийг урд оны мөн үетэй харьцуулахад 5 нэгжээр буюу 0.6 хувиар, алба хаагч 18 нэгжээр буюу 2.0 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

-Монгол Улсын Засгийн газраас “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” энэ оны 258 дугаар тогтоолыг баталсантай холбоотой цагдаа, дотоодын

¹Цагдаагийн ерөнхий газар., “Улсын хэмжээнд 2018 оны гуравдугаар улиралд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ” Улаанбаатар хот., 2018 он.

цэргийн байгууллагаас уг тогтоолыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан, хэрэгжүүлж байна.

-Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/130 дугаар тушаалаар цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчдын албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлага, үйл ажиллагааны үр дүн, мэргэшил, ур чадварын ерөнхий түвшингийн дүн, үнэлгээтэй холбогдуулан шалгалтад хамрагдсан аймаг дахь цагдаагийн газар, хэлтсүүдэд зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

-Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/159 дүгээр тушаалаар Замын цагдаагийн алба, Төмөр зам дахь цагдаагийн газар, Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтсийг нэгтгэн “Тээврийн цагдаагийн алба”, Мэдээлэл нэгтгэн боловсруулах газар, Мэдээллийн технологи, холбооны төв, Мэдээлэл, шуурхай удирдлагын төв, Шуурхай удирдлага, ажиллагааны хэлтсийг нэгтгэн “Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба”-ыг тус тус байгуулж, ажиллах чиг үүргийг тодорхойлон, үйл ажиллагааг жигдрүүлсэн.

Зургаа. Санал

-“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх.

-Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2018 онд дэвшүүлсэн зорилт, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг зохион байгуулах замаар гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх.

-Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг урд оны мөн үетэй харьцуулахад тодорхой хэмжээнд өссөн үзүүлэлттэй байгаад дүгнэлт хийж, гэмт хэргийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулж, үр дүнг тооцох.

-Алба хаагчдын сахилга, хариуцлагыг сайжруулах чиглэлээр сургалт, соён гэгээрүүлэх ажлыг шинэлэг хэлбэрээр зохион байгуулах.

-Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж буй “Эрүүл цагдаа”, “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёлыг төлөвшүүлэх хөтөлбөр”-ийн явц, байдалд тогтмол хяналт тавьж, үр дүнг тооцох.

-Орон нутгийн замын цагдаагийн хяналтын 27 пост, Мөрдөн байцаах албаны барилгын гүйцэтгэлтэд хяналт тавьж, төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах, замын цагдаагийн хяналтын постод ажиллах олон нийтийн цагдаагийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлэх.

-Өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүрэн хангаж, хэрэгжүүлэх.

-Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “Зэвсэг 2018”, “Илрүүлэлт-Оргодол-Шийдвэрлэлт 2018” нэгдсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах.

-Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгүүд /хөтөлбөр, төлөвлөгөө, тушаал, шийдвэр/-ийн гуравдугаар улирлын биелэлтийг тооцож, дөрөвдүгээр улиралд зохион байгуулах ажил, арга хэмжээг төлөвлөн, бүрэн хэрэгжүүлэх.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР